

“Монгол алт” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн ээлжит

хурлын тэмдэглэл.

“Монгол алт” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн ээлжит хурал 2010.04.26-ны өдрийн 09⁰⁰ цагт “Монгол-Алт” ХК-ийн хурлын танхимд эхлэв. Хуралд 140508 ширхэг саналын эрхтэй 7 хувь нийлүүлэгч оролцлоо.

Хурлын ирц 52.8 %-тай байгаа нь компанийн тухай хуулийн шаардлагыг хангаж байх тул хурлыг эхлүүлэв. Хурлын даргаар Б.Саруулыг сонгов.

Хурлаар : 1. Компанийн 2009 оны санхүүгийн тайлан

2. ТУЗ-ийн ажлын тайлан

3. ХШЗ-ийн ажлын тайлан

4. Ногдол ашиг тараах тухай

асуудлуудыг хэлэлцэхээр санал нэгтэй тохиров.

Хурлын дотоод журмын дагуу ТУЗ-ийн тайланг Б.Саруул, ХШЗ-ийн тайланг ХШЗ-ийн гишүүн С.Дорждэрэм, Санхүүгийн тайланг ерөнхий ня-бо Ж.Мягмаа нар танилцуулав.

Хурлын дарга: Эдгээр тайлангуудтай холбоотой асуулт, санал шүүмжлэл байвал гишүүд тавьж болно.

Хувь нийлүүлэгчдээс тайлангуудтай холбоотой асуулт, санал, шүүмжлэл гараагүй тул санал нэгтэй батлахаар болов.

Хурлын тооллогын комисс хурлаар хэлэлцэж буй асуудлуудаар санал хураалт явуулахаар хувь нийлүүлэгчдэд санал хураалтын хуудсыг тарааж санал хураалтыг явууллаа.

Хурлын тооллогын комисс санал хураалтын дүнг хувь нийлүүлэгчдэд танилцуулав.

Шийдвэрлэсэн нь: ТУЗ болон ХШЗ-ийн ажлын тайлан, Санхүүгийн тайланд дүгнэлт өгөх, ногдол ашиг олгох тухай санал хураалтын дүнг үндэслэн хувь нийлүүлэгчдийн хурлаас дараах тогтоолууд гарав.Үүнд:

1. ТУЗ болон ХШЗ-ийн ажлын тайлан, Санхүүгийн тайланг хувь нийлүүлэгчид “ сайн “дүнтэйгээр батлав.
2. Ногдол ашгийг нэгж хувьцаанд 100 төгрөг олгохоор батлав.

Хурлын дарга тогтоолуудыг танилцуулж хурлыг албан ёсоор хаав. Хурал 12 цаг 30 минутанд дуусав.

Тэмдэглэл хөтөлсөн: .....Б.Батжаргал